



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№64 /508/

2023.04.18

Цаг үе, үйл явдал

## ЗХЖШ-ЫН ДАРГА БРИГАДЫН ГЕНЕРАЛ С.ГАНБЯМБА ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 123 ДУГААР АНГИД АЖИЛЛАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 123 дугаар ангид энэ сарын 18-ны өдрөөс ажиллаж байна.

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямбыг тус ангийн Хүндэт харуул угтан авсны дараа ангийн захирагч хурандаа Х.Энхболд дэлгэрэнгүй танилцуулга хийсэн юм.

Энэ үеэр хурандаа Х.Энхболд ангийн түүх,

дайчин уламжлал, өнөөгийн байдал, шинээр хийж нэвтрүүлсэн бүтээлч ажлууд, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулсны зэрэгцээ ёс зүйтэй байж, цэргийн алба хаагчдын сахилга хариуцлагыг бэхжүүлэх, тэдний бүтээлч санаачлагыг дэмжих тал дээр анхаарч ажиллаж байгаагаа онцлов.

Үүний дараагаар ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тус ангийн штаб, цэргийн байр, цэргийн гал тогоо, соёл, спортын төв, номын сан, сургалтын нэгдсэн төв болон бусад объектуудтай

танилцсан бөгөөд тулгамдаж буй асуудлуудын талаар мэдээлэл авсан юм.

ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба энэ үеэр "Энэ онд залуу офицер, ахлагч нарын манлайллыг дээшлүүлэх эрхэм зорилтыг дэвшүүлсэн бөгөөд нийт цэргийн алба хаагчдын ажиллаж, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, идэвх санаачлагатай ажиллах"-ыг үүрэг болгов.

Ахмад Г.ОЮУН

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	☁️ 28

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,490	3,494
EUR 🇪🇺	3,835	3,860
CNY 🇨🇳	510	511.70
RUB 🇷🇺	42,60	42,90
JPY 🇯🇵	26.10	26,40
KRW 🇰🇷	2.66	2,68

### ЗУРХАЙ

2023.04.19 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 29

ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.56-19.47

Барилдлага:

Рашаан

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Мунхрахуй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

## “БИД МАНЛАЙЛАГЧ” ЗӨВЛӨГӨӨН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДААР ҮРГЭЛЖИЛЛЭЭ



18-ны өдөр Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын оролцоогоор үргэлжиллээ. Зэвсэгт хүчний Жанжин штабаас зарласан "Залуу офицер, ахлагчийн манлайллын жил"-тэй уялдуулж зохион байгуулагдсан энэхүү зөвлөгөөнөөр хугацаат цэргийн алба хаагчдад "Эр хүн байхын учир", "Цэргийн алба-Эрх зүйн ухамсар", "Цэргийн тангараг таны насан туршийн андгай" зэрэг цэргийн алба болоод хувь хүний хүмүүжил, төлөвшил талд нь сургаж өгөх хичээл сургалт, уулзалт ярилцлагыг явуулсан юм.

байдгийг онцоллоо.

"Эр хүн гэдэг байгалийн өгөгдлөөрөө ч тэр гэр орон, улс орноо авч явахаас бус залуурч, хойш сууна гэж яав ч байж таарахгүй зүйл. Та нар харин эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, үнэ цэнтэй, бахархал дүүрэн нэг жилийг өнгөрүүлж байгаа нь цэргийн албанд ирээгүй үеийнхээ залуусаас ухамсар, хүмүүжлээрээ хавь илүү гэдгийг нь илтгэж байгаа юм. Та нараар би бахархаж байна" гээд хариуцлагатай эр хүний тухай яриа өрнүүллээ.

Мөн Хуурай замын



Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин П.Цэрэндагва хугацаат цэргийн алба хаагчдад хэлэхдээ "Жүжигчин гэдэг зөвхөн дэлгэц, тайзнаа жүжиглээд байх бус ард түмнийг соён гэгээрүүлэх их үйлсийн төлөө зүтгэдэг онцлогтой мэргэжил. Өнөөдөр Монгол Улсын ирээдүйг авч явах золбоо хийморьтой цэрэг эрстэйгээ уулзаж, өөрийн өчүүхэн туршлага сургамжаа ярьж байгаадаа баяртай байна. Та бүхэн халагдаад аав болно, бүсгүй хүний хань болно" гээд аав, ээжийгээ энэрэх, ахан дүүсээ хүндэтгэх, хань ижлээ зөв сонгож, хайраар дутаалгүй авч явах үүрэг хариуцлага эр хүн бүрт

цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр нийгмийн хөгжлөө дагаад хугацаат цэргийн алба хаангаа өөрийгөө хөгжүүлэх, суралцах олон боломжууд байдгийг тодотгож, түрүүч, байлдагч нарын санал сэтгэгдлийг сонсож, харилцан ярилцав.

Арга хэмжээний төгсгөлд ЦДБЭЧ-ын "Military Band" хамтлаг болон Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театр, Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн авьяаслаг түрүүч, байлдагч нар урлагийн тоглолт толилуулснаар "Бид манлайлагч" зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдаж, өндөрлөсөн юм.

Ахмад Д.БОЛОР

Өмнөд бүсийн Зэвсэгт хүчний анги, салбаруудын офицер, ахлагч нарын "Бид манлайлагч" зөвлөгөөн, хэлэлцүүлэг Зэвсэгт хүчний 167 дугаар ангийг түшиглэн амжилттай зохион байгуулагдлаа.

Зөвлөгөөнд оролцогчид сахилга хариуцлагыг бэхжүүлэх, хувь хүний ёс зүй, манлайлал, хандлагыг төгөлдөржүүлэх, цэргийн үнэт зүйлс, бахархлыг түгээн дэлгэрүүлэхэд ямар

их үүрэг хариуцлагыг хүлээж байдаг талаар номын дуу сонсож, бүлгээр дасгал ажил гүйцэтгэж, төгсгөлд нь гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнээр өрсөлдсөн юм. Тэмцээний тэргүүн байрт Зэвсэгт хүчний 167, дэд байрт Зэвсэгт хүчний 256, гутгаар байрт Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн баг тамирчид шалгарч, шагнагдав.

"Бид манлайлагч" зөвлөгөөн хоёр дахь өдрөө буюу 4 дүгээр сарын



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 685,806,155

Эдгэрсэн

Нийт: 658,571,889

Нас барсан

Нийт: 6,843,505

Цахим шууданд

# ХЭЭРИЙН ТҮЙМРИЙГ УНТРААХАД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИУД ГАР БИЕ ОРОЛЦЛОО



Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Хадын булаг багийн Уртын цагаанаас гарсан хээрийн түймэр энэ сарын 09-10-ныг шилжих шөнийн 02:00 цагт Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт орж ирсэн тул Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 329 дүгээр тусгай ротын бие бүрэлдэхүүн галын дохиогоор түргэн шуурхай ажиллаж РЛ-ын постоо хамгаалан 20-30 метрийн зайд түймрийг ямар нэгэн хохиролгүйгээр унтраажээ.

Халхгол сумын нутагт орж ирсэн хээрийн түймэр гамшгийн байдалд хүрч 10 гаруй айл өрх орон гэргүй болж, 3000 гаруй мал үрэгдсэн. Харин хүний амь нас эрсдээгүй байна.

Үүссэн нөхцөл байдалд тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 329 дүгээр тусгай ротын бие бүрэлдэхүүн нь хүнс, хувцас, ахуйн хэрэглээний зүйлсээр нутгийн иргэдэд хандив тусламж үзүүлсний зэрэгцээ Улсын Онцгой комиссоос түймэрт өртсөн айл өрхүүдэд олгосон гэрийг тааруулж, иж бүрдлийг нь бүрэн шалган барьж хүлээлгэн өгчээ.

## ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА БОЛЛОО



Архангай аймагт шинээр дугаар ангид офицер, ахлагчийн байгуулагдсан барилга, инженер, албан тушаалд томилогдон, экологийн Зэвсэгт хүчний 342 цэргийн сургалт бэлтгэлд тодорхой

хугацаанд хамрагдсан бүрэлдэхүүний "Цэргийн тангараг" өргөх ёслолын ажиллагаа ҮБХИС-ийн байрлалд зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд ҮБХИС-ийн захирал, профессор, бригадын генерал П.Жаргалан оролцсон бөгөөд Зэвсэгт хүчний эгнээнд элсэж байгаа баяр хүргэж, цэргийн тангараг дор ажиллаж амьдрах өндөр үүрэг хариуцлага өнөөдрөөс ирж байгааг онцлолоо. Цэргийн албатай хувь заяагаа нэгэнт холбосон бол чин үнэнчээр зүтгэж, сахилга хариуцлага, ёс зүйгээрээ нийгэмд манлайлагч байхыг ч тэрээр тодотгоод Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам зэрэг улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалтад оролцсон үйлсээр бахархаж буйгаа ярилаа.

## ЭХ ОРНЫ ЭР ЦЭРЭГ ХҮҮТЭЙ ГЭДГЭЭРЭЭ БАХАРХАЖ ЯВААРАЙ, ЭЭЖ МИНЬ ...



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн хугацаат цэргийн алба хаагчдынхаа дунд "Ээждээ захидал бичээрэй" уралдааныг зохион явуулжээ. Энэ нь цэргийн албаар бахархаж буйгаа ээждээ илэрхийлэх гүүр нь болсноороо онцлог бөгөөд уралдаанд байлдагч Э.Төгөлдөр тэргүүлж, дэд түрүүч С.Эрдэнэтөгөлдөр дэд байрт, байлдагч Н.Уранхолбоо гутгаар байрт тус тус шалгарсан юм. Эрхэм уншигч та бүхэнтэй хамт байлдагч Э.Төгөлдөрийн ижийдээ илгээсэн захидлыг

хамтдаа задалъя. Сайн байна уу, ээж ээ. Сайн сууж байна уу, танд захидал очих өдрийн мэндийг хүргэе. Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн цэргийн байраас ээж тандаа хүү нь захидал бичиж сууна. Нэг л мэдэхэд ээжийн эрх хүү эх орны хүү, эр цэрэг болжээ. Энэрэл хайраар та намайг дутаагаагүй шиг эх орон минь ч гэсэн юугаар ч дутаалгүй, бас элдвээр гоочлолгүй, үеийн нөхөд,

онжавуудтайгаа хамт цэгцэрсэн жагсаалын цэрэг болголоо.

Өсөж торнисон цагаасаа хойш эцгийн нөмөр уулыг түшиж хэвтээгүй ч гэсэн ээж таныхаа энгэрт эрхэлж өдий хүрсэндээ хүү нь талархаж явдаг билээ. Цэлмэг тэнгэрт нэг л наран байдаг шиг миний зүрхэн тэнгэрт цэлмэсэн ганцхан наран та юм шүү. Ээжийгээ үлдээгээд цэрэгт мордохдоо хэдий эр цэргийн золбоо хийморь албанд ирлээ гээд баярлаж байсан ч хайртай таныгаа үгүйлэн санаснаа нуухгүй ээ. Ангир уургийг тань шимж өссөн болохоор сэтгэлийн минь наран цор ганц таныг юм байна гэдгийг эр цэргийн албанаас илүү ихээр мэдэрлээ хүү чинь.

Ээж минь та хүүдээ санаа зовох хэрэггүй. Цэргийн албанд хүү нь өнгө, жавхаатай, нөхдөдөө түшигтэй, даргадаа дэмтэй сайхан явна аа. Сайхан албанд хүү нь ирсэн учир танд санаа сэтгэл зовох юу байх сан билээ. Эх орны эр цэрэг нь болсон хувь тохиолдоо талархаж, эх орон, ээж, элгэн садан, нутаг орноо хайрлах сэтгэл дүүрээд ирдэг нь энэхүү цэргийн албаны онцлог гэлтэй. Эх орондоо тангарагтай хүүтэй ээж гэдгээрээ та минь бахархах, омогших бүрэн эрхтэй шүү. Ээж минь тандаа хүү нь маш их хайртай. Биеэ сайн бодож, хоёр дүүг минь миний өмнөөс үнсээрэй за. Таны хүү, эх орны хүү байлдагч Э.Төгөлдөрөөс

Ахмад Д.БОЛОР



## АХЛАХ АХЛАГЧ Д.ЧУЛУУНБААТАР УЛСЫН АВАРГААС МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Монголын Шинкиокушинкай каратэгийн 2023 улсын аварга шалгаруулах тэмцээний "кумитэ" төрлийн -65 кг-ын жинд Зэвсэгт хүчний 350 дугаар ангиас амьд гарах гардан тулааны багш ахлах ахлагч Д.Чулуунбаатар оролцож дэд байрт шалгаран цом, мөнгөн медаль, өргөмжлөлөөр шагнууллаа.

Ахмад Г.ЭРДЭНЭХҮҮ

## ГАР НИЙЛЭМЖТЭЙ АЖЛЫН ҮР ДҮНД...



Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн офицер ахлагч, ажилтан албан хаагчид өөрсдийн дотоод нөөц бололцоо, хамтын хандиваар бие бүрэлдэхүүний хооллох заалыг орчин үеийн жишигт нийцүүлэн шинэчлэн засварлаж, офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын ая тухтай хооллох орчин нөхцөлийг бүрдүүлсэн түргэн хоолны газрыг нээж үйл ажиллагааг эхлүүлээ.

Энэхүү арга хэмжээнд ангийн удирдлага, хамт олон оролцож, түргэн

хоолны газраас бие бүрэлдэхүүнд үйлчлэх хоолны төрөл, танилцуулгыг сонслоо. Энэ үеэр ангийн удирдлагын зүгээс хоолны эрүүл ахуй, чанар байдалд онцгой ач холбогдол өгч ажиллахыг даалгаж, ажлын амжилтыг хүслээ.

Уг түргэн хоолны газрыг ангийн ахлагчийн зөвлөл хариуцан ажиллуулах юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 337 ДУГААР АНГИ

## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТААР...



Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн офицер, ахлагч нарт энэ сарын 16-ны өдөр "Хүний эрхийг хамгаалагчийг тодорхойлох нь" сэдвийн хүрээнд хүний эрх, эрх чөлөө, халдашгүй дархан байдал, эрүү шүүлт зэрэг асуудлаар Монголын "Эмнести интернэшнл" байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг нар сургалт явууллаа.

Сургалтаар хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдлэг олгох,

хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлагыг төлөвшүүлэх зорилготой бөгөөд "Бид аюулгүй байдлаа хангахгүйгээр хөгжилд хүрч чадахгүй, хөгжихгүйгээр аюулгүй байх аргагүй. Харин хүний эрхийг хүндэтгэхгүйгээр бид эдгээрийн алиныг ч бий болгож чадахгүй" гэсэн нэгдсэн ойлголтод хүрэв.

Мөн Дорноговь аймгийн Цагдаагийн газрын ГХУСАХ-ын ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч Ч.Ганзориг энэ сарын 18-ны өдөр "Цахим гэмт хэрэг, түүнээс хэрхэн сэргийлэх" сэдвээр бие бүрэлдэхүүнд мэдээлэл өглөө.

Ахмад А.АЛТАНХУЯГ